



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/239

Булган сум

**Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны  
зөвлөгөөн зохион байгуулах тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны VI хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын “Ёс зүйтэй, хариуцлагатай салбар” удирдах ажилтны зөвлөгөөний хөтөлбөрийг 1 дүгээр, зөвлөгөөний зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу, үр дүнтэй, өргөн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Нарантуяа)-т даалгасугай.

3. Дээрх зөвлөгөөнд зарцуулагдах 2,285,000 (хоёр сая хоёр зуун наян таван мянга) төгрөгийг “Эрүүл Булган” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. ПҮРЭВ-ОЧИР

6326010324

Аймгийн Заасаг даргын 2026 оны 04 дугаар сарын 06 ыг өдрийн 06 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН “ЁС ЗҮЙТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ САЛБАР”  
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Сэдэв	Хугацаа	Зохион байгуулагч
2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр			
1	Бүртгэл	8.30-9.00	ЭМГ-ын мэргэжилтнүүд
2	Нээлт	9.00-9.10	ЭМГ Аймгийн ЗДТГ-ын НБХ
3	ЭМБ-уудын 2025 оны жилийн эцсийн аудитын дүгнэлт, анхаарах асуудал	9.10-09.20	Аудитын газар
4	Өмчийн бүртгэл мэдээлэл	09.20-09.40	Орон нутгийн өмчийн газар
5	ЭМДҮЗ-ийн 3 дугаар тогтоолын танилцуулга мэдээлэл	09.40-10.20	ЭМДХ
6	Төрийн албаны ёс зүйн тухай хууль, холбогдох дүрэм журам	10.20-10.40	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн мэргэжилтэн Ж.Оюунгэрэл
Цайны завсарлага 10:40-11:00			
7	“Хамт олны үнэ цэнэ”	11.00-12.00	“Харилцааны гайхамшиг” ТББ-ын тэргүүн Н.Алтанцоож
8	МУЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”	12.00-12.30	Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсийн дарга Ч.Цогбуян
9	Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS7068:2025	12.30-13.00	СХЗХ-ийн мэргэжилтэн Л.Туяа
Өдрийн хоолны завсарлага 13:00-14:00			
10	Аймгийн НЭ-ийн мэдээлэл	14.00-14.20	НЭ-ийн ЭЭО Д.Бүрэндондов
11	ЭМС-ын 2025 оны товч мэдээлэл, цаашид анхаарах асуудал	14.20-14.40	ЭМГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нарантуяа
12	ЭМТҮ-ний чанарын жилийн ажлын тайлан	14.40-15.00	ЭМГ-ын ЭТҮХ-ийн дарга Д.Отгонсүрэн
13	ЭМС-ын 2025 оны ХШҮ-ний дүн танилцуулах	15.00-15.10	ЭМГ-ын ХШҮМХ-ийн дарга Б.Урангаваа
14	Шилдэг хамт олон, ажилтнуудад шагнал гардуулах үйл ажиллагаа	15.10-15.30	ЭМГ

Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар  
сарын 06 ы/ий өдрийн 120 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН “ЁС ЗҮЙТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ  
САЛБАР” УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ**

№	Шаардлагатай зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнэ (төгрөг)	
				Нэг бүр	Нийт
1	Шилдэг байгууллагын өргөмжлөл	Ширхэг	3	95,000	285,000
2	Шилдэг ажилтаны цом	Ширхэг	11	90,000	990,000
3	“Алтан чагнуур” цом	Ширхэг	1	260,000	260,000
4	“Хамт олны үнэ цэнэ” лекц	Цаг	1	750,000	750,000
	<b>Нийт</b>				<b>2,285,000</b>

--o0o--